

Л.БЭГЗЖАВ
“МОНГОЛ, ХЯТАДЫН ХАРИЛЦАА (1949-1999)

Монголын нэрт түүхч, дорно дахинч, нанхиад судлаач, академич Ч.Далайн гарын шавь, хятад судлаач эрдэмтэн Лхашидын Бэгзжавын “Монгол, Хятадын харилцаа (1949-1999) хэмээх нэгэн сэдэвт бүтээл 1999 оны сүүлчээр хэвлэлээс гарчээ.

Хятад судлаач Л.Бэгзжавын энэ бүтээл өмнөтгөл, 3 бүлэг, 8 зүйл, төгсгөл, ишлэл зүүлт гэсэн үндсэн хэсгүүдээс бүрдэл болжээ.

Өмнөтгөл хэсэгтээ зохиогч монгол хятадын харилцааны түүхийн тойм, энэ чиглэлээр гадаад дотоодын эрдэмтдээс туурвисан бүтээлүүд түүний ололт дутагдал тухайн цаг үеийн байдал, олон улсын болон хоёр орны харилцааны төлөв зэргийг системтэй эрэмбэ дараалалтай, нягт нямбай авч үзээд өнөөгийн нөхцөлд хөрш гүрэнтэйгээ Монгол улсын тогтоон хөгжүүлж буй харилцааны уламжлал шинэчлэлийн асуудлыг нарийвчлан авч үзэх бодитойгоор үнэлэлт дүгнэлт өгөх цаг нэгэнт болсон учир шалтгааныг тодорхой гаргасан байна.

Судлаач “БНМАУ, БНХАУ-ын хооронд шинэ эрх тэгш эрт харилцаа тогтон хөгжсөн нь (1949-1962) гэсэн тэргүүн бүлгийн “БНМАУ, БНХАУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосон түүхэн нөхцөл, хүчин зүйл” гэсэн 1-р зүйлдээ тухайн түүхэн цаг үеийн байдал, энэ үед Дундад иргэн улсаас монголын талаар баримталж байсан бодлого, хоёр орны хооронд дипломат харилцаа тогтсон озэрэг олон асуудлыг монгол, хятад эх сурвалжуудыг ашиглан системчлэн авч үзээд нэгтгэн” БНХАУ байгуулагдаж Монгол, Хятадын ард түмний хооронд шинэ маягийн харилцаа тогтоосон нь Ази болон даян дэлхийн энх тайвны үйл хэрэгт, түүнчлэн олон улсын харилцаанд байр сууриа эзэлсэн, айл хөршийн найрсаг сайн харилцааны үлгэр жишээ болсон” гэж дүгнэсэн байна. /119 дэх тал/

Зохиогч тэргүүн бүлгийн “Хоёр улсын харилцааны эрх зүйн үндэс тавигдсан нь” гэсэн 2-р зүйлдээ хөрш хоёр орны төр засгаас хоёр талдаа найрсаг айлчлалт хийж, харилцааны эрх зүйн баримт бичгийг бүрдүүлэх чиглэлээр хэрхэн хүчин зүтгэл гаргаж ирснийг түүхэн баримтад тулгуурлан авч үзсэн байна. Ялангуяа 1953-1959 онд хоёр орны хооронд хэлэлцээр, худалдааны зээлийн хэлэлцээр, төлбөрийн хэлэлцээр, Хятад, Зөвлөлтийн Иргэний агаарын тээврийн компаний онгоц БНМАУ-ын хилийн дотор нислэг хийх нөхцөлийн протокол, жил бүр соёлын хамтын ажиллагааг хэрэгжүүлэх төлөвлөгөө, хятад ажилчдыг Монголын үйлдвэрлэл, бүтээн байгуулалтанд оролцуулах тухай хэлэлцээр, монгол ажилчдыг хятадад үйлдвэрлэлийн дадлага хийлгэх нөхцөлийн тухай хэлэлцээр, Монгол

Хятадын хилийн төмөр замын хэлэлцээр, радио нэвтрүүлгийн хамтын ажиллагааны хэлэлцээр, Хятадаас Монголд эдийн засаг техникийн тусламж үзүүлэх тухай хэлэлцээр байгуулж хэрэгжүүлж ирсэн болохыг тодорхой тусгажээ. Түүнчлэн зохиогч Монгол, Хятад улсын хамтын хүчин чармайлтаар хоёр орны хоорондын хилийн шугамыг нарийвчлан тогтоож Монгол, Хятадын хооронд түүхээс үлдэн хоцорсон шийдвэрлэвэл зохих асуудлыг амжилттай шийдвэрлэж чадсан нь Монгол Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдалд чухал ач холбогдолтой үйл явдал гэж дүгнэсэн байна. /3-р тал/

Хятад судлаач эрдэмтэн Л.Бэгзжав тэргүүн бүлгийн “Хоёр орны эдийн засаг, худалдаа, соёлын харилцаа төлөвшиж хөгжсөн нь” гэсэн гутгаар зүйлдээ 1951-1961 онуудад хоёр орны худалдааны хэмжээ тухайн үеийн ханшаар 750 мянган 49,9 сая ам.доллар /тухайн үеийн ханшаар/ болж өссөний дотор 45,8 сая ам.доллар, импорт 4,1 сая ам.доллар болж өссөн болохыг статистикийн тоо баримтанд тулгуурлан дурьдаад “1960 он гэхэд хоёр орны худалдааны хэмжээ түүхэндээ хамгийн өндөр түвшинд хүрч тухайн үеийн ханшаар 44,5 сая ам.долларт хүрсэн” гэж дүгнэжээ /38 дахь тал/

Зохиогч “ЗХУ, Монгол, Хятад гурван улсын хөрш орныг холбосон төмөр зам тавих тухай 1952 оны гурван талын хэлэлцээрийн үндсэн дээр ЗХУ-ын санхүү, техник ажиллах хүчний тусламжаар Монголын нутагт 1400 гаруй км төмөр зам тавьж, Хятад улс Зининь-гээс Эрээн хүртэл төмөр зам тавин Монголын төмөр замтай холбосон хөрш гурван орны найрамдал, хамтын ажиллагааг өргөтгөх, ялангуяа Монголын эдийн засгийн хөгжилд чухал ач холбогдолтой үйл явдал болсон” гэж дүгнээд БНХАУ импорт, экспортын ихэнхи бараагаа Монгол улсын төмөр замаар дамжуулж, жил бүр Хятадын экспортын барааны төлбөрийг Монголын талд төмөр замаар дамжин өнгөрсөн тээврийн зардлаар нь төлж байсан нь Монгол Хятадын худалдааны харилцааны тодорхой нэг онцлог байсан болохыг зохиогч зөв зүйтэй дүгнэн харуулсан байна. /38-р тал/

Судлаач Л.Бэгзжав цааш нь төмөр зам ашиглалтанд орсноор төмөр замын транзит тээврээс манай улсын төсөвт 1956 онд 50 сая, 1957 онд 98 сая, 1959 онд 100 сая гаруй төгрөг тус тус орсон нь Монгол улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд зохих хувь нэмэр оруулсан гэж дүгнэжээ. Түүнчлэн хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагааны нэг хэлбэр нь Хятад улсаас манай улсад олгож байсан буцалтгүй тусламж, хөнгөлттэй зээл байсан бөгөөд 1956-1959 онд манай улсад хуучин ханшаар 17 сая ам.долларын буцалтгүй тусламж үзүүлж, 1958 оны хэлэлцээрийн дагуу хятадаас 11 сая гаруй ам.долларын зээл тус тус олгосон. Энэ нь тухайн үедээ Монгол улсын эдийн засгийг хөгжүүлэхэд багагүй үүрэг гүйцэтгэсэн гэж зөв зүйтэй тэмдэглэжээ. /41-43 дэх тал/

Зохиогч 1949-1962 оны үеийн Монгол, Хятадын харилцаанд зарим нэг бэрхшээл тохиолдож байсан боловч бүхэлдээ урагшлан хөгжиж, хоёр орны харилцааны түүхэнд нэн чухал, нааштай үүрэг гүйцэтгэсэн харилцааны үе байсан гэж зөв зүйтэй дүгнэсэн байна. /49 дэх тал/ “Социалист байгуулалтын үеийн хоёр улсын харилцааны хөгжил ба бэрхшээл /1960-1980/ гэсэн дэд бүлгийн “БНМАУ, БНХАУ-ын улс төрийн харилцаа муудаж, эдийн засгийн хамтын ажиллагаа буурсны үр дагавар” гэсэн 1-р зүйлдээ хүйтэн дайны үеийн олон улсын харилцааны хөрс дэвсгэр дээр тулгуурлан Монгол, ЗХУ, Монгол, Хятад улсын харилцаа хамтын ажиллагааны байдлыг авч үзээд Хятад улстай тогтоосон эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны бууралт, түүний учир холбогдлыг тоймлон авч үзээд энэ бүхэн нь бүхэлдээ Монгол улсын гадаад худалдаа, улсын төсөвт нэлээдгүй хохирол учруулсан гэж дүгнээд үүнийгээ статистикийн тоо баримтанд тулгуурлан тодорхой харуулсан байна. /68 дэх тал/

“БНМАУ-д социалист харилцаа тогтсон үеийн хоёр орны хамтын ажиллагаа, тохиолдсон бэрхшээл” гэсэн 2-р зүйлдээ зохиогч тухайн үеийн хоёр орны нам төрийн бодлого үйл ажиллагааг нэлээд ултай авч үзээд, Хятадын нам төрийн бодлогын зарим алдаатай бодлого, үзэл баримтлалын асуудалд Монгол улс нэн хүлээцтэй хандаж, нам, төрийн албан ёсны баримт бичигт БНХАУ-ын бодлогыг эрс шүүмжлэх хандлага гаргаагүй болохыг энд онцлон тэмдэглэсэн байна. /81-р тал/

Монгол, Хятадын харилцаанд 1982 оноос хойш нэлээд нааштай ахиц гарч эхэлсэн төдийгүй жил бүр алхам алхамаар урагшилсаар 1987 он гэхэд хоёр орны хооронд шинжлэх ухаан техник, төмөр зам, иргэний агаарын тээврийн үйлчилгээ сэргэж, олон нийтийн байгууллагуудын хамтын ажиллагаа идэвхжих суурь нөхцөлийг бүрдүүлсэн үе гэдгийг зохиогч зөв зүйтэй дүгнэсэн байна. /87-р тал/

“Ардчилал, зах зээлийн нөхцөл дэх Монгол, хятадын харилцааны хөгжил /1990-1999/” хэмээх гутгаар бүлгийн 1-р зүйлдээ: “Монгол улсын гадаад бодлогын шинэ үзэл баримтлал, түүхэн хувь заяагаар холбогдсон хоёр хөрштэйгээ харилцах харилцааны уламжлал шинэчлэлийн асуудлыг хөндсөн байна. Хөрш Хятад улс. Монгол улсын ардчиллыг дэмжиж хоёр улсын харилцааг улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын бүх салбарт эрчимтэй хөгжүүлэх бодлого баримталж, зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн үеийн монголын эдийн засгийн бэрхшээлийг даван туулахад БНХАУ-аас олон талт тусламж дэмжлэг үзүүлж, хоёр орны худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх талаар дорвитой арга хэмжээ авсаар байгааг тодорхой баримтаар системтэй авч үзсэн байна.

“Монгол улс, БНХАУ-ын харилцааны агуулга, хүрээ өргөжиж, үр өгөөж дээшилсэн нь” гэсэн 2-р зүйлдээ зохиогч “Хоёр орны худалдааны хэмжээ 1980 онд 11,6 сая ам.доллар байсан бол 1990 онд 41,0 сая ам.доллар болж өссөн. Өөрөөр хэлбэл энэ хугацаанд хоёр талын худалдаа 3,5 дахин өссөн төдийгүй манай гадаад худалдааны хоёрдогч том түнш болсныг эдийн засгийн бүх үзүүлэлтээр тодорхой харуулсан байна /109-115 дэх тал/

Зүүн хойт Азийн Интеграц ба Монгол, Хятадын харилцааны хэтийн төлөв” гэсэн 3-р зүйлдээ судлаач тус бүс нутгийн интеграцид хоёр улс хамтран ажиллах нөөц боломж, түүний хэтийн төлөвийг ул үндэстэй судлан авч үзсэн байна. Манай ахмад нанхиад судлаачдын халааг залгамжилсан дунд үеийн хятад судлаачдын дунд зохих байр сууриа эзэлсэн, олон тийш гуйвж савалгүй нэгэн чиглэлээр олон жил нухацтай, даацтай хийсэн судалгааны ажлынх нь үр дүн болсон энэ бүтээлд цаашдын судалгаандаа лавшруулан судлах зүйл ч ажиглагдана. Тухайлбал, Хятад улсын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа түүний мөн чанар, хятадын хоёр удаагийн /1992, 1995 он/ нийт 100 сая юаны зээлийг Монгол улс хэрхэн юунд ашиглав? Ямар үр дүнд хүрэв? Монгол, Хятадын хамтарсан компаниуд болон 100 хувийн хөрөнгө оруулалттай компаниуд гол төлөв ямар салбарт ажиллаж юу бүтээж, ямар хувь нэмэр оруулж буй, манай ноолуурын үйлдвэрлэлийн салбарт Хятадын бизнесменүүд хэрхэн нэгдэл нягтралтай ажиллаж ямар үр дүнд хүрч байгаа, хилийн худалдаа түүний эерэг, сөрөг тал гэх мэт олон асуудлыг мэргэшсэн хятад судлаачийн хувьд Монгол улсын үндэсний эрх ашиг, аюулгүй байдалтай нягт уялдуулан гүнзгийрүүлэн судалж ултай үнэлэлт, дүгнэлт өгнө гэдэгт эргэлзэхгүй байна.

Эцэст нь тэмдэглэхэд Монгол, Хятадын харилцааны хагас зуун жилийн түүхийг даяарчлалын өнөөгийн өндөрлөгөөс харж, аливаа үзэл суртлаас ангид, зөвхөн судлаачийн байр сууринаас улируулан судалж нэгтгэн дүгнэсэн энэ бүтээл нь Монгол улсын гадаад харилцааны түүхийг судлан боловсруулах, их дээд сургуулийн түүх, олон улсын харилцаа, орон судлалын хичээлийн сургалтанд гарын авлага болгох, хоёр орны харилцааны түүхийг сонирхогч, судлаач, багш, оюутан, гадаад харилцааны ажилтан, олон нийтийн байгууллага зэрэгт лавлах материал болох практик ач холбогдолтой шинэлэг бүтээл болжээ.